



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/778

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Есөнзүйл сумын сум дундын эмнэлэг, сумдын Эрүүл мэндийн төвүүдэд 2020 онд хэрэглэгдэх эм эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Ганболд -аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Б.Пүрэвсүрэн -аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Р.Наранцэцэг -аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ю.Ичинноров -аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга

Н.Оюунтуяа -аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Б.Одсүрэн -Мерсу кор ОУБ-ын Өвөрхангай аймаг дахь зохицуулагч (зөвшилцсөнөөр)

П.Чимэг -Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж архив-бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101455